



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 9/168

Булган сум

«Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх
тусгай зөвшөөрлийн тухай»

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1, 8.1 дүгээр зүйлийн 12 дугаар хэсгийн 12.13, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.3, 16 дугаар зүйлийн 16.1, 16.2, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/04 дүгээр тушаалаар батлагдсан “Согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтын журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. «Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл» олгох цэгийн нэрийг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү Захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/22 дугаар захирамжийн А.Дэлгэрмаа захиралтай “Зуун наст фарм” ХХК-ийн “Хүлэг” хүнсний дэлгүүртэй холбогдох заалтыг хүчингүйд тооцсугай.

3. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2.1, 35.2.2-т заасан тэмдэгтийн хураамжийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхийг сумын Засаг дарга, Татварын газар (Д.Лхагвасүрэн), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Давааням)-т тус тус даалгасугай.

4. Дээрх цэгүүдийн үйл ажиллагаанд холбогдох хууль, журам, стандартуудын хэрэгжилтийг ханггуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (хурандаа Б.Эрдэнэбилэг), Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Шүрэнцэцэг), Стандарт, хэмжил зүйн хэлтэс (Д.Алтаншагай), сумын Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад тус тус үүрэг болгосугай.



Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн тухай

0325010246
засаг дарга
захирамж
дэлгүүр

Аймгийн Засаг даргын 2025 оны
23 дугаар сарын 07 ны/ний өдрийн 11:18 дугаар
захирамжийн хавсралт

**“СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ” ЭЗЭМШИХ ЦЭГИЙН НЭРС**

№	Сумын нэр	Аж ахуйн нэгжийн нэр	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн овог, нэр	Үйлчилгээний төрөл	Бар, ресторан, дэлгүүрийн нэр
1	2	3	4	5	6
1	Хишиг-Өндөр	“Азтай Аюуш” ХХК	Б.Отгонцэцэг	Хүнсний дэлгүүр	“Отгоо”
	Нийт-1				